



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 04 сарын 24 өдөр

Дугаар А/483

Ховд

Ажил эрчимжүүлэх тухай

“Барилгын тухай” Монгол Улсын хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.1 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар орон нутаг хэрэгжиж байгаа төсөл арга хэмжээ, бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэн хяналтыг сайжруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Т.Жаргалсайхан -Аймгийн Засаг даргын орлогч

Гишүүд

Ч.Багдал

-Аймгийн Засаг даргын Тамгын газрын  
Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга

Ц.Ганданповрон -Аймгийн Засаг даргын Тамгын газрын  
Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого,  
төлөвлөлтийн хэлтсийн даргын үүргийг  
түр орон гүйцэтгэгч

П.Эрдэнэчулуун –Мэргэжлийн хяналтын газрын дарга

Б.Баярсүх

-Газрын харилцаа, барилга, хот  
байгуулалтын газрын дарга

2.Хуулийн хүрээнд хяналтыг сайжруулж, бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэн ажиллахыг Мэргэжлийн хяналтын газар, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, Техникийн хяналтын орон тооны бус зөвлөл, Барилга угсралтын компаниуд холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3.Ажлын талаархи тайланг 14 хоног тутамд гаргаж зөвлөлийн хуралд танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч /Т.Жаргалсайхан/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

03.02384  
D/Zax-A/483-Da